

М.АМАРХҮҮ

БҮМ БҮММИЙН АЙМШИГТ ГАНЦЛААР ДАМ



Бага
ангийнханд
зорцуулаа.

Бүм бүмийн аймшигт ганцаардал
Эрхлэн гаргасан: Болор судар хэвлэлийн газар
Зохиолч: М.Амархүү
Редактор: З.Пүрэвсүрэн

ISBN: 978-99962-1-471-8

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Бүм бүмийн аймшигт ганцаардал

Энэхүү сонирхолтой үйл явдал өрнөхөөс өмнө тэрээр зүтгүй, дээрэнгүй, эрх дураараа бас бардам хүүхэд байлаа.

Тэр нэгэн өглөө түүнийг сурсан зангаараа аажуухан босоход цонхоор нарны гэрэл урьдын адил туяаран асгарч байлаа. Бүм бүм зөөлөн алхалсаар цонх руу очиход Арслан хотын сүм хөх байшингууд өглөөний нам гүмд дугжирч буй цэв цэнхэр луу мэт харагдана. Өрөө нь ундуй сундуй бөгөөд тэртээ буланд буй түшлэггүй алтлаг сандал дээрх хивс хөсөр унаж үнэт алмааз талстан бүрхүүл нь талаар нэг тарсан өнчин ганц чийдэн утаснаасаа санжигнах нь шөнө үүгээр салхин авхай морилсныг гэрчлэх мэт.


Бүм бүм эмх замбараагүй хөглөрөх ваар сав, торгон хөшиг дундаас хувцас хунараа нэг нэгээр нь цуглуулан углаж аваад гарч одлоо. Хачирхалтай нь тасран хийсэх намрын навчсын чимээг эс тооцвол гудамж нам гүм байлаа.

Замаар өдөр шөнөгүй оволзон давалгаалж байдаг машин тэрэг, гудамжаар шивээлсэн тариан түрүү мэт долгион алхаж байдаг хүн зон хаачив? Яав? Юу болов?

Хар өглөөгүүр “Сонин аваарай! Сонин аваарай!” хэмээн хашгиран гүйдэг цэнхэр нүдэн хүү, хоёр гар нь гялалзан гутал тосолжүдэш болтол үл амардаг сахалт Махмуд, ууртай хэрцгий цагдаа Рой Жонс ч байдаггүй.


Аймаар юм. Их хот чив чимээгүй дүнсийнэ. Бүм бүм маш их гайхлаа. Аугаа их Арслан хотод золбин муур, нохой ч үл үзэгдэх тул хачин нам гүм орчинд гав ганцаараа байгаагаа мэдэрсэн Бүм бүм хүү гэнэт учиргүй чангаар цурхиран уйллаа.

Хэсэг уйлаад тайвшран бодлогоширон суутал гэнэт нэг сонин мэдрэмж төрлөө.



Хүмүүс хаачив? Хот яагаад эзгүйрэв? Дэлгүүр хоршоо, банк, тоглоомын газар, цагдаагийн хэсэг бүгд эзгүй.

Тэрээр эргэн тойрноо сайтар ажиглан харснаа зүүгээр хатгуулсан мэт гэнэт огло харайн босч өчигдөрхөн шоглож гомдоосон найз Бархасбадийнх руугаа хар хурдаараа жирийлгэлээ.





Тэднийх аварга том модны сүүдэр доор орших хуучин улаан гантиган байшинд амьдарч байв. Далдуу модны том том далбагар навчсыг мөрөөрөө шүргэн борооны дуслууд үсчүүлсээр байшингийн хуучин довжоон дээр түүнийг үсрэн гарахад нүсэр том модон хаалга нь онгорхой байлаа. Уржнан жил Өмнөд Америкаас авчирсан хөгшин цацагт хяруул хүлээлгийн өрөөний хонгилд амьгүй мэт хөшжээ. Нүд нь үл хөдлөх тэрбээр сахиусан тэнгэрүүдэд илбэдүүлсэн бололтой.


Бархасбадийнд хүн амьтан байсангүй. Бүм бүм гайхсаар алтадмал нүсэр тавилга бүхий зочдын өрөөнд орвол саяхан хүртэл Бархасбадиас гуйж байсан хүнд дуулга, бамбай илд бүхий ромын баатрын хүрэл баримал байх нь тэр. Үг дуу ч үгүй шурхийн очоод мөнөөх баримлыг тэвэрч аваад эргэв. Хүсч мөрөөдөж байсан мөнөөх баримлаа сохор зоос ч төлөлгүй өөрийн болгож авсандаа тэрээр нэн баяртай байлаа.

Зүрхэн хэлбэрт алтлаг навчсаар шуурсан гудамжаар түүнийг уруудан явахад гудамжны эсрэг талд “Алтан элээ” банкны захирлын “Цөлийн шуурга-3” маркийн нүсэр хүнд суудлын тэрэг

алтан тоногуудаа наранд гялбуулан байх нь баян хатагтай үнэт зүүсгэлээ солонгоруулан зогсох мэт санагдах ажгуу.

Овор ихгэй энэхүү гялалзсан тас хар тэргийг банкны захирал байнга унаад шилэн сэхээвчээр нь янжуурын нялуун угаа суунаглуулан явдаг байлаа. Бүм бүм гүйж очоод хүнд хаалгыг нь нилээд хүч гарган онгойлгоод мөнөөх баатрын баримлаа арынх нь суудал дээр тавиад хаалгыг алгуурхан хаав. Ингээд эзгүй хотод энэхүү машин түүний хоёрдугаар халдашгүй өмч болов. Одоо дараагийн өмч нь юу вэ?

Тэрээр өчүүхэн ч эргэлзэлгүйгээр “Алтан элээ” банкны чамин тоноглол бүхий хаалганы бариулаас зоримогхон татлаа. Захирлын өрөөний хаалгаар шагайвал өрөөг нэлэнхүйд нь хулдсан араб хивсний голд дорно зүгийн хятад маягийн хийц бүхий гоёмсог ширээ байв.



Ширээн дээр хөглөрөх торгон хавгастай номууд, бичиг бүхий цаас, үзэг сэлтийг гүйлгэн хартал том мөнгөлөг гархи бүхий шармал түлхүүрүүд харцыг нь булаах аж.

Агшин зуурт л сэтгэлийг соронздон татах, хязгааргүй эрх мэдлийн бэлгэдэл болох эдгээр

Түлхүүр нь “Алтан элээ” банкны мөнгөний түлхүүрүүд билээ.

Лусын хааны эрдэнэсийн санг олзлох мэт сэтгэлийн хөөрөлд автсан Бүм бүм нэн баяртайгаар мөнгөний авдруудыг нээж байлаа. Туркийн султаанд л баймаар толгой эргэм их мөнгөнд хоромхон зуур умбах нь тэр. Цочирдсондоо золтой л уулга алдсангүй. Даахынхаа хэрээр тэвэрч увуулж цувуулж унаган байж машиндаа ачлаа. Хэдхэн мөчийн дараа тэрээр Арабынхаанаас ч илүү баян болсон мэт сэтгэгдэлтэйгээр машиныхаа жолоон дээр гар тавилаа.

Гялалзсан хар тэрэг дугуйныхаа мөнгөлөг хүрдийг солонгоруулан давхисаар “Үнэгэн сүнс” аймшгийн галерейн гадна ирж зогслоо. Дээр доороо орон ноцолдож буй шулмас чөтгөрийн баримал бүхий довжоо өөд өгсөн мушгирсан могойн хэлбэр бүхийбаруулаас нь татаж хаалгаар шагайвал тасалгаанд дүнсгэр нам гүм, бүүдгэр саарал ахуй ноёлох ажээ. Өлмий дээрээ зөөлөн алхалсаар явгал чанх урд нь музейн эзэн аймшигт мангас Сангасваа хилэнтэйгээр харж зогсоно. Гэвч тэрээр огт хөдөлсөнгүй. Учир нь тэр бас илбэдүүлсэн бололтой. Зүрх нь дэлсэн байсан Бүм бүм төдөлгүй тайвширч Сангасваагийн гараас анх удаагаазоримогхон атгалаа.



Цөлийн гүрвэл ганц нүдэт Хабилуула, хоёр толгойт арслан Мехлис, усны үхэр Арман, цөөвөр чоно Шүдэт гээд урьд нь түүний үнхэлцгээ хагартал айдаг байсан аймшгийн олон амьтан огт хөдөлгөөнгүй, анир чимээгүй зогсоцгоох нь зогсоцгоож, хэвтэцгээх нь хэвтэцгээх аж. Зоригжсон Бүм бүм Мехлисийн аманд толгойгоо шургуулж Арманы нуруун дээр зогсон цөөвөр чонын шүднээс барьж өөрөө авагч дуран авайгаар зургаа авахууллаа.


Түүнийг нэн жаргалтайгаар галерейгаас гарч ирэхэд наран авхай баяртайгаар мишээж алтлаг цацрагууд нь гэрэлтэн байлаа.

Үд дундын халуун наранд Арслан хотын өндөр өндөр харшуудын мянга мянган цонх гэгээвч борооны дараах навчсын болорлог шүүдэр адил гялтганан гялалзах нь тун үзэсгэлэнтэй харагдана. Бүм бүмийн дараагийн зогсоол нь “Хар ташуур” зодооны клуб байлаа.

Энэхүү бүлэг зодоончдын толгойлогч нь Бой хэмээх догшин эр байдаг бөгөөд тэрээр дээр үед “Тэнгисийн эрлэг” хэмээх хөлөг онгоцны ахмад, далайн дээрэмчдийн ахлагч байжээ. Нэг удаа тэр Бүм бүм, Бархасбадь хоёрыг зээл дээр олны өмнө ташуурдан дээрэлхэж байсан билээ. Хот даяараа түүнээс эмээдэг байлаа.

“Цөлийн шуурга-3” гэрэл дохиогоо гялалзуулсаар “Хар ташуур” клубийн үүдэнд ирэхэд догшин Бой довжоон дээрээ хялайн зогсоно. Үргэлж тас нясхийлгэж явдаг гайхал ташуур нь өмнө нь хэвтэнэ. Өнөөх ташуурыг нь шүүрч аваад Бой руу далайтал мань эр ер хөдөлсөнгүй. Тэгэхээр нь тэр чигт нь буулгаж орхитол мань Бой нүдээ ч цавчсангүй. Урьдын явдлаа санаад хэд хэд ороолгож орхилоо.

Хариугаа авсандаа сэтгэл нь уужирсан Бүм бүм мөнөөх ташуурыг чулуудчихаад тэрэг рүүгээ гүйж одлоо. Одоо энэ хотод түүний үйлдлийг зогсоох, үг хэлэх хүн нэгэнт байхгүй тул тэрээр их л бардам байлаа.




Хүүг наранд гялбасан нүдээ онийлгон инээмсэглэн зогсоход замын нөгөө талд орших байшингийн гоёмсог цонх нүднийх нь үзүүрт солонгоров. “Элбэг дэлбэг” супермаркет. Өмнө нь мөнгө зоосгүй өлөн зэлмүүн явахад чиний үнэтэй хүнс бараанууд их л өнгөлөг харагддаг байлуу гэж санан ачаатай мөнгөнөөсөө атга атгаар шүүрч аваад гүйж ортол мөнөөх гял цал дэлгүүр мөн л эзгүй байлаа. Түүнд мөнгөний ч хэрэг байсангүй. Амтат тарвас, утсан хيام, хачиртай талх, чихэр жимс тэргүүтэн түүнийг хүлээх мэт алаглан байв.

Сонирхолтой нь худалдагч нар нь түүнийг дураараа дургихад ямар ч саад хийсэнгүй. Араб хивс, швецарь цаг, япон торго гээд гартаа баригдсанаас нь л зөөж байлаа. Дэлгүүрийг ямар ч эсэргүүцэлгүй талж орхисон Бүм бүмийг гэрийнхээ гадна тоормослоход үд дунд хэвийж байв.

Хэдхэн мөчийн дараа тэрбээр “Үлэг гүрвэлийн төгөл” амьтдын парк руу давхиж явлаа. “Цөлийн шуурга-3” тэрэгтэйгээ том том далдуу модны сүүдэр доогуур салхи татуулан давхиж явахад замын хажуугаар урт хүзүүт цоохор анааш их л гайхсан байдалтай харах аж. Далдуу модны навчсын завсраар алаг тахь, эрээн ирвэсүүд жирэлзэн өнгөрч байлаа. Зам

голлон хөдөлгөөнгүй зогсох аварга том зааны хошууг шүргэн алдаад түүнийг зогсоход парк даяар нам гүм байв. Агаарт тогтсон эрвээхийнүүд, харайгаад тогтсон тэмээн хяруул мэтийг тэрээр ихэд сонирхон ажиг бүлгээ.

Тэдгээр бүх амьтны нүд нь ч хөдлөхгүй байв. Шидэт цаг хугацаа тэдэнд ч бас үйлчилсэн бололтой. Агаарт эргэлдэн тогтоод сарниагүй элсэн хуй түүний анхаарлыг ихэд татав. Зүггүй бяцхан сармагчин модны мөчрөөс дүүжлээстэй чигээрээ хөшжээ. Хөшсөн бяцхан сармагчинг ачаан дээрээ даруулаад цааш хөдөллөө.



“Далайн дээрэмчдийн ундаа” хэмээх сүржин нэртэй дарсны мухлагийн дэргэдүүр өнгөрч “Жимсний гудамж”-инд буй “Эрвээхий гүнж”-ийн харшийг чиглэлээ.

Үүлс сүвлэсэн өндөр харшийн өмнөх цагаан гантиган талбайг тэрэгнийхээ алтан тоногуудаар гялбалзуулан зогсоход цовоо дэгжин Эрвээхий гүнж довжоон дээрээ инээмсэглэн гарч ирсэнгүй. Эрвээхий гүнжийн эцэг нь “Арслан” хотын захирагч цог жавхлант ван Рубрук бөгөөд тэдний өвөг дээдэс Атиллагийн дайнд үе залгамжилсан жанжин

сайдууд явсан гэх бүлгээ. Үлэмж нүсэр тансаг харшийн үнэт чулуун шатаар өгсөж явтал далдуу модны сүүдэр туссан бүүдгэр ногоон тавцан дээр Эрвээхий гүнжийн хамгаалагч Мухаммед ташаан дахь сэлмээ хуйнаас нь дутуу сугалаад зогсож байв. Мэндэлтэл огт дуугарсангүй. Түүний үнсэн хөх царайн дахь хүйтэн инээмсэглэл эртний Египетийн фараонуудын хүнд нүсэр чулуун баримлуудын царцсантөрх шиг харагдах авай.

Урьд өмнө нь өөрийг нь үл анзаардаг, “Үлгэрийн хаант улсаас матрын арьсан гутал авчирч өгье, үерхэе!” гэж мянгантаа гуйгаад зөвшөөрөөгүй эрхэмсэг Эрвээхий гүнж хамгаалагчийнхаа ард сувдан шигтгээ бүхий болор сандал дээр хөдөлгөөнгүй сууж байв.

Бүм бүм түүн рүү гүйж очоод гар дээрээ өргөн гарч явлаа. Тэрээр үзэсгэлэнт дэгжин Эрвээхий гүнжийг тэргэндээ суулгаад хотын захирагч эцгийнх нь “Хүчирхэг бүргэдийн эрх мэдэл” хэмээх ордон руу нь зүглэлээ.





Олон луу могой ороолдон сүлжилдсэн дүрс чимэгтэй алмаазан гоёл бүхий сэнтий дээр эрхэмсэг цог жавхлантай ван бодлогоширон суух агаад түүний дэргэд тамга сахигч Ягуар ирвэс нь ярзайн хэвтэх аж. Вангийн хөдөлгөөнгүй гөлийх нүдийг анзаарсан Бүм бүм өвөр дээр нь гарч суулаа.

Өмнө нь зурагтаар л харж нэр сүрийг нь дуулж явсан хязгааргүй эрх мэдлийн бэлгэдэл болсон хэн ч халдашгүй хүний өвөр дээр гарч суусандаа Бүм бүм нэн баяртай байв.

Бүм бүмийн дараагийн очих газар нь чидун жимсгэний цэцэрлэгт хүрээлэнд орших “Ай кү юү” хэмээх сургууль нь байлаа. Арслан хотын томчууд, баячуудын хүүхдүүд сурдаг уг сургуулийн хэсэг хүүхэд урьд нь Бүм бүм болон түүний нөхдийг нүд үзүүрлэн шоглодог байсан ажгуу. Тэдний толгойлогч нь Багваахай хочит Хуан байсан бөгөөд үргэлж хорлонт санаа агуулж явдаг түүнийг Бүм бүм хэзээ нэгэн цагт хашраана гэж дотроо санаж явлаа.

Нөгөөтэйгүүр үзэсгэлэнт Эрвээхий гүнж догшин хэрцгий Хуанд талтай байдгийг нь Бүм бүм гадарладаг байв. Эрвээхий гүнж түүнийг Ромын зоригт баатруудтай адилтган бодлогоо Бүм

бүмд нэг бус удаа дурджээ. Энэ нь Хуаныг үзэн ядах Бүм бүмийн сэтгэлийг улам бүр бачууруулна.






Сургуулийн хонгилд Хуан болон түүний дээрэнгүй нөхөдтэй тааралдан амьгүй мэт үл хөдлөх тэднийг бахаа ханатал занчиж эцэст нь “Сарны нулимс” хэмээх хиймэл цөөрөмд хаяж орхиод санаа нь амарлаа. Хуаны далбагар бүрх малгай цөөрмийн замаг зулсан ногоон уснаа далбилзан хөвөх нь далайн дээрэмчдийн сүйрсэн онгоцыг санагдуулахуйц сонин ажгуу. Болдогсон бол болж өнгөрч буй агшин бүрийг Эрвээхий гүнжид үзүүлмээр л байлаа. Санаа нь амарсан Бүм бүм ангидаа орж багшийнхаа ширээний шургуулгыг онгойлгож шалгалтын дэвтрээ гаргаж ширээн дээр тавилаа. Муруй сарий бичсэн тооны дэвтр дээр нь муу хэмээх дүн цөлийн эрээн могой мэт цогнолзож байх нь тэр. Дургүй нь хүрсэн Бүм бүм дэвтрээ шүүрч аваад гарч одлоо. Шатаар уруудан гүйж явсан Бүм бүм мөнх ногоон хөвдөнд гялалзах борооны мөнгөлөг шүүдэрт нүд нь гялбаж зогтусав. Замын хажууд түм буман өвс сүлжин орших шоргоолжны вант улсын мянга мянган алтан үүр чимээгүйхэн солонгорохыг тэрээр ажаад нам гүм анир чимээгүйг нь мэдрэн гунигт автлаа. Өмнө нь тэрээр шоргоолжны үүр бусниулж явснаа санахуй шоргоолжны вант улсын олон мянган оршин суугчдын өмнө түмэн буруутайгаа ойлгожээ.


Бүм бүм үзэмж төгс гоёмсог тэрэгнийхээ шил толийг гялбуулан давхисаар цэцэгсийн хүрээлэнгийн дэргэд ирж үзэсгэлэнт мандарваа цэцгийн мандлын дэргэдэх болор сандал дээр Эрвээхий гүнжийг гар дээрээ өргөн авчирч суулгалаа. Чухамхүү цэцгэн дээр суусан эрвээхийн эрхэмсэг зохирлыг тэндээс л харж болохоор байлаа.


Бүм бүм үүнийг хараад нэн их баяртай байлаа. Учир нь багваахай хочит Хуан Эрвээхий гүнжийг хэзээ ч ингэж баярлуулахгүй байсан биз. Хэсэг хугацааны дараа Бүм бүм “Диваажингийн сүм” хэмээх циркийн хаалгыг татлаа. “Диваажингийн сүм” циркийн догшин захирал хирс хочит Жураб довжоон дээрээ нүүгэлтэн зогсох нь сүрдмээр байсан ч Бүм бүм түүнийг өчүүхэн ч тоосонгүй.



Шидэт цаг хугацаа ноёлох нүсэр багана бүхий хонгилоор явсаар амьтан сургалтын тасалгааны хаалгаар шагайв. Аварга том заан нүсэр биендээ тээртэх мэт залхуутайяа зогсоно. Бүм бүм зааныг унаж үзэхсэн гэж үргэлж боддог байсан бөгөөд хүслээ гүйцэлдүүлэх нэн таатай боломж нээлттэй байгааг мэдэрч байв. Хөдөлгөөнгүй зогсох заан өөд шат тавин авирч дээр нь гарч зогслоо.

Болдогсон бол энэ агшныг Эрвээхий гүнжид харуулах юмсан гэж бодов. Даргай цагаан заан унаж хүслээ гүйцээсэн Бүм бүм циркийн зэргэлдээ орших цөөрөмд хөвөгч аймшигт матрын нуруун дээр сүндэрлэгч “Илбэч ертөнц” театрын босгоор давлаа.Түнэрлэг харанхуй, нүсэрлэг ихэмсэг байдал зонхилсон театрын тайз гэрэлтэн харагдах нь бүрэнхийд мандах саран мэт үзэгдэх авай.





Энэ тайзнаа тавигдаж байсан “Хилэнцэт хорхойн үхэл” жүжгийн муу санаат хааныг Бүм бүм урьд нь үзэн ядаж байжээ. Өнчин охиныг хэрхэн ад үзэж буйг нь бодохоос түүний хорслын гал дүрэлзэн асах бүлгээ. Өст хүн өлийн даваан дээр гэгчээр өнөөх муу санаат хаан тайзнаа ташуураа өргөн зогсож байв. Өнчин охин өмнө нь бөхрөн суусан нь өндөгнийхөө дэргэд инээмсэглэх тогоруу мэт харагдана. Бүм бүм гүйн гарч огт хөдөлгөөнгүй зогсох муу санаат хааныг сөхрүүлэн суулгаад өнчин охиныг түшин босгож гарт нь ташуур бариулаад сая нэг санаа нь амарлаа.

Түүний санаагаар бол жүжгийн үйл явдал ингээд л цаашаа өрнөх ёстой байлаа. Бүм бүмийг театрт байх үед оройн нарны зурвасхан шаргал гэгээ Арслан хотын тэнгэрийн ивээлт сүмүүдийн алтлаг хэрээсүүд дээр цацарч үзэгдэнэ.

Өмнө нь гэрэлтэгч сарны хөхөлбий туяа хотыг нэлэнхүйд нь хулдаж эхэлмэгц Арслан хотынхны шөнийн амьдрал эхэлдэг байлаа.


Гэтэл энэ шөнө үргэлж мөнхийн шаналгаат шуугиан үл тасрагч их хот хачин намуун ажин

түжин байлаа.

Шидэт цаг хугацаа, хувь заяаны тохиолоор ч гэсэн нэгэн бүтэн өдрийн турш Арслан хотын эзэмшлийг атгасан Бүм бүм дотроо их л таашаалтай байсан ч аймшигт ганцаардлын аялгуу түүнийг мөч бүр тойрон эгшиглэж шаналгагч цагийн харангыг нь дэлдэх амой.

Хязгааргүй эрх мэдэл, санхүүгийн эрх чөлөө бүгд байсан хэдий ч хүн ганцаардвал ямархан их сэтгэлийн тамд унадагийг хүн төрөлхтөн төдий л анзаардаггүй билээ.

Маргааш наран мандана... Арслан хотын бүхий л амьдрал урьдын хэвэндээ орно. Тэгвэл Бүм бүм яасан их баярлах бол оо...





Бүм бүм хүүгийн аймшигт ганцаардлын учир шалтгаан чухам юунд байсныг олсон уу? Мэдээж номд дуртай мэргэн дүү нар маань учрыг нь олж хужрыг нь тунгаасан гэдэгт итгэлтэй байна.

“БОЛОР СУДАР” хэвлэлийн газрын ах эгч нар нь дараагийн удаа та нартаа хүүхдийн олон зохиолчийн шилдэг бүтээлээс түүвэрлэн хүргэнэ!



Table of Contents

[Бүм бүмийн аймшигт ганцаардал](#)